



LOS ANGELES ТОЙРОГ

СОНГУУЛИЙН УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2022



DEAN C. LOGAN

Бүртгэгч-Тэмдэглэгч/Тойргийн Ажилтан

АГУУЛГА

УДИРТГАЛ.....	3
СОНГОГЧИЙН СОНГОЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ	3
LOS ANGELES ТОЙРОГ ДАХЬ VCA ХЭРЭГЖИЛТ.....	4
1-Р ХЭСЭГ – СОНГОГЧИЙН БОЛОВСРОЛ БОЛОН ХҮРЧ ҮЙЛЧЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ	5
1-A ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ БОЛОН ХҮРЧ ҮЙЛЧЛЭХ ТӨСӨВ	6
1-B ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХҮРТЭЭМЖ.....	7
1-C ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦОО.....	11
1-D ВЕБСАЙТЫН МЭДЭЭЛЭЛ.....	14
1-E ХЭЛНИЙ ТУСЛАМЖ	14
1-F ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДЛЫН ДЭМЖЛЭГ	16
2-Р ХЭСЭГ – САНАЛ ӨГӨХ ТӨВ, САНАЛЫН ХУУДАСНЫ ХАЙРЦГИЙН БАЙРШИЛ	19
2-A САНАЛ ӨГӨХ ТӨВ	19
2-B САНАЛЫН ХАЙРЦАГ	21
3-Р ХЭСЭГ – САНАЛ ӨГӨХ ТӨВИЙН БҮТЭЦ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, АЖИЛЧИД.....	21
3-A АЖИЛЧДЫН ЛОГИСТИК, ОЛОН ХЭЛНИЙ ҮЙЛЧИЛГЭЭ.....	21
3-B САНАЛ ӨГӨХ ТӨВИЙН ТУСЛАМЖ	23
3-C САНАЛ ӨГӨХ ТӨВИЙН БҮТЭЦ.....	23
4-Р ХЭСЭГ – АЮУЛГҮЙ БАЙДАЛ, САНАМСАРГҮЙ ТОХИОЛДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	24
4-A АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АРГА БА СТАНДАРТ	24
4-B САНАЛ ӨГӨХ ТӨВИЙН ДЭМЖЛЭГ	24
4-C КИБЕР ХАМГААЛАЛТ.....	25
4-D САНАМСАРГҮЙ ТОХИОЛДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	25
5-Р ХЭСЭГ – УРАГШЛАХ НЬ	26

УДИРТГАЛ

Los Angeles тойрог (тойрог) нь 4,100 хавтгай дөрвөлжин миль талбайд оршин суух, бүртгэгдсэн 5.7 сая гаруй сонгогчтой, улсын дотоодын санал өгөх хамгийн том харьяа нутаг юм. Бүртгэгч-Тэмдэглэгч/Тойргийн ажилтан (RR/CC) нь энэ харьяа нутгийн хүрээнд орон нутаг, муж улс, холбооны сонгуулийг зохион байгуулж, бүх сонгогчдыг ардчиллын үйл явцад оролцох мэдлэг, хүртээмж, боломжоор хангах үүрэгтэй. RR/CC нь сонгогч сонгуульд оролцоход саад болж болох бэрхшээл, саад тотгорыг арилгахын зэрэгцээ нийтийн эзэмшлийн болон нийтэд зориулан боловсруулсан саналын систем болох Бүгдэд Хүртээмжтэй Санал Хураалтын Шийдэл (VSAP)-ээр дамжуулан санал өгөх нөхцөл байдлыг сайжруулахаар тасралтгүй, хичээнгүйлэн ажилладаг. VSAP шийдэл нь тав тухтай, хүртээмжтэй, аюулгүй байдал хангах олон төрлийн сонголттойгоор Тойргийн сонгогчдод санал өгөх илүү их боломж олгохыг зорьдог орчин үеийн, хүртээмжтэй, аюулгүй санал өгөх дадлага бөгөөд; энэ нь California даяар санал өгөх сонголтыг арвижуулах хүчин чармайлттай нийцнэ.

Мөн California муж улс (Муж улс) нь сонгогч сонгуульд хэрхэн, хэзээ, хаана саналаа өгөхийг дахин тодорхойлж, санал өгөх хуулийн хүртээмжтэй байдлыг дэлгэрүүлж, шинэчлэн өөрчлөхийн тулд урьд өмнө нь хийж байгаагүй алхмуудыг хийсэн. Сенатын Билл 450, Калифорнийн сонгогчийн сонголтын тухай хуулийг (VCA) энэ хүртээмжтэй байдлыг хялбарчлах зорилгоор боловсруулсан.

Энэхүү баримт бичигт RR/CC сонгогчдод санал өгөх эрх, сонголтын талаар хэрхэн сургах төлөвлөгөөтэй байгаа тухай; Санал өгөх төв, Саналын хуудасны хайрцгийн байршлыг хэрхэн хуваарилах, байршуулах, тохинуулах; Санал өгөх төвийн бүтэц, санал өгөх төхөөрөмж, боловсон хүчний төлөвлөгөөний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл; аюулгүй байдал, гэнэтийн төлөвлөгөө; болон дараагийн алхамуудын талаар дэлгэрэнгүй байна.

СОНГОГЧИЙН СОНГОЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ

VCA нь илүү уян хатан байдал, тав тухыг хангаж сонгогчдод илүү олон сонголтыг санал болгох үндсэн тогтолцоог тойргуудад бүрдүүлж өгдөг. VCA загварын үндсэн гол элементүүд нь:

- Биечлэн санал өгөх уян хатан сонголт нь 11 хоногийн хугацаанд оршин суух тойргийнхоо аль ч Санал Өгөх Төвд саналаа өгөх боломжийг сонгогчдод олгодог.
- Болзолт санал өгөгчийн бүртгэлийг оролцуулан Санал өгөх төвүүдэд сонгогчдод үзүүлэх үйлчилгээ, тусламжийг сайжруулсан.

- Сонгуулийн өдөр болохоос 29 хоногийн өмнөөс эхлэн Саналын хуудасны хайрцаг болон саналын хуудас өгөх аюулгүй бөгөөд тав тухтай газрууд болон Шуудангаар санал өгөх (VBM) үйлчилгээ бэлэн болно (2-Б хэсгийг үзнэ үү).

VCA-н санал хураалтын загварыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд тойргууд нь санал өгөх технологи, төсвийн хүчин чадал, санал өгөх газар, олон нийтийн оролцоо зэрэг одоогийн нөхцөл байдал, үйл явцыг сайтар судлах шаардлагатай.

LOS ANGELES ТОЙРОГ ДАХЬ VCA ХЭРЭГЖИЛТ

Тойрогт VCA-г хэрэгжүүлэхийн тулд RR/CC нь загвар, хүртээмж, аюулгүй байдал, технологи, сонгуулийн удирдлага, эрдэм шинжилгээний ажилтан, оролцогч талын нийтийн санал, олон нийтэд түшиглэсэн байгууллага (CBOs), ард олны гишүүд буюу салбарын мэргэжилтнүүдээс бүрдсэн зөвлөх хороодоор баталгаажуулж, сонгогчдын хэрэгцээнд тохируулж одоогийн өөрчлөгдөж болох VSAP зарчмууддаа тулгуурлан дэд бүтцийг хөгжүүлсэн. Зөвлөх баг, судалгаа, чиглэгдсэн бүлэг, техникийн дүн шинжилгээ, хэрэглэгчийн туршилтыг хослуулан ашиглан RR/CC нь Муж улсын болон орон нутгийн шаардлагад нийцсэн, сонгогчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн мөн үндэсний сонгуулийн системийн аюулгүй байдлын стандартаас давсан санал хураалтын шинэ дадлагыг хөгжүүлэх цогц үйл явцыг удирдан чиглүүлж, тогтоосон.

2020 оны гуравдугаар сарын 3-ны Ерөнхийлөгчийн анхан шатны сонгуульд тойрог нь VSAP санаачилгыг хэрэгжүүлж, сонгогчдод бүрэн хүртээмжтэй, аюулгүй Саналын хуудас дээр тэмдэглэгээ хийх төхөөрөмж (BMD), Сонгогчдын цахим бүртгэл (ePollbook), Интерактив загвар саналын хуудас (ISB), Алсаас шуудангаар санал өгөх боломж (RAVBM), шинэчлэгдсэн Tally систем, 10 хоногийн биечлэн эрт санал өгөх хугацаа, Санал өгөх төвүүд, Санал өгөх Мобайл/Уян хатан хөтөлбөрийг багтаасан дадлагыг сонгогчдод танилцуулсан. Энэхүү VCA болон VSAP-ийн анхны хэрэгжилтээр 1.14 сая гаруй сонгогч VBM саналын хуудсаа ашиглан саналаа өгсөн бол өөр сая гаруй сонгогч Санал Өгөх Төвд саналаа өгсөн байна. Энэхүү ирцийн үзүүлэлтээр 2018 оны зургадугаар сард болсон тойргийн анхан шатны сонгуулиас VBM-ийн ирц ойролцоогоор 75%-иар, нийт ирц 42%-иар өссөнийг, 665,000 орчим сонгогч Шуудангаар санал өгөх саналын хуудсаа ашигласныг харуулж байна. RR/CC-ийн явуулсан судалгаагаар сонгогчдын 70% нь ерөнхийдөө хэвийн эсвэл эерэг хандлагатай байжээ.

2020 оны гуравдугаар сарын 3-ны Ерөнхийлөгчийн анхан шатны сонгуулийн дараа тойргийн Удирдагчдын зөвлөлөөс (Зөвлөл) Сонгуулийн тухай хуулийн 4005 ба 4007(с)-д тусгагдсаны дагуу

VCA-н заалтуудыг батлахыг RR/CC-д шууд даалгасан бөгөөд Тойргоос бүртгэлтэй бүх сонгогчдод VBM саналын хуудсыг шуудангаар явуулахыг шаардсан. Энэхүү эрт батлах үйлдэл нь COVID-19 цар тахлын эхэн үед өөрийн эрүүл мэнд, гэр бүлийнхээ эрүүл мэндэд эрсдэл учруулахгүйгээр гэрээсээ аюулгүй санал өгөх боломжийг сонгогчдод олгосон. Энэ нь 2020 оны гуравдугаар сарын 3-ны өдрийн Ерөнхийлөгчийн анхан шатны сонгуультай харьцуулахад 2020 оны арван нэгдүгээр сарын 3-ны өдрийн Ерөнхий сонгуулиар шуудангаар илгээсэн VBM саналын хуудас ойролцоогоор 2.5 саяар нэмэгдсэн гэсэн үг юм. Энэ удаагийн сонгуульд 3.4 сая гаруй сонгогч Шуудангаар санал өгөх эрхээ ашиглан санал өгч, ойролцоогоор 913,000 сонгогч биечлэн саналаа өгсөн байна. 2018 оны арван нэгдүгээр сард болсон өмнөх тойргийн сонгуулийн нийт ирцтэй харьцуулахад энэ нь 58%-иас 76% болж өссөн ба 4.3 сая сонгогчийн ирцтэй түүхэн үзүүлэлт болсон байна. RR/CC-ийн явуулсан судалгаагаар саналаа өгсөн оролцогчдын 94% нь санал өгөхдөө хэвийн эсвэл эерэг хандлагатай байж, сонгогчдын сэтгэл ханамж нэмэгдсэнийг харуулжээ.

1-Р ХЭСЭГ – СОНГОГЧИЙН БОЛОВСРОЛ БОЛОН ХҮРЧ ҮЙЛЧЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

RR/CC нь олон нийтэд зориулсан стратегийн боловсрол, хүрч үйлчлэх кампанит ажил явуулж бүртгэлтэй болон сонгууль өгөх эрхтэй боловч бүртгэлгүй сонгогчдын дунд санал өгөх эрх, санал өгөх сонголт, VCA, VSAP санал өгөх дадлага, сонгуулийн арга боломжид хэрхэн хандах талаар сургалт явуулж, мэдлэгийг дээшлүүлэх ажлыг үргэлжлүүлнэ. VSAP болон VCA-г хэрэгжүүлж, баталснаас хойш RR/CC нь Тойрог даяар олон сая сонгогчдыг оролцуулсан олон хэл, олон соёлт сонгогчдын боловсролын гурван томоохон кампанит ажлыг хэрэгжүүлсэн. Эдгээр кампанит ажлаар сонгогчдод асар олон хэлээр чухал зурвас өгч, сонгогчдыг манай вебсайт дээр болон үнэгүй утсан дээрх олон нийтэд нээлттэй мэдээлэл, нөөцөд чиглүүлсэн олон төрлийн тактик, стратегийг ашигласан. RR/CC нь зах зээл дээр бэлэн байгаа өгөгдөлд суурилсан шилдэг дадал туршлага, арга барил, харилцаа холбооны платформуудыг ашиглан кампанит ажлыг үргэлжлүүлэн боловсруулж, хэрэгжүүлнэ.

Түүнчлэн RR/CC нь телевиз, радио, хэвлэл, дижитал мэдээллийн хэрэгслээр дамжуулан хэвлэл мэдээллийн боломж олж авахын тулд орон нутгийн болон олон хэлээр мэдээлэл өгдөг мэдээллийн сүлжээтэй харилцах харилцаагаа үргэлжлүүлэн ашиглаж хөшүүргээ болгоно. Эдгээр боломжид саналын болон сонгуулийн үйл явцтай танилцахад туслах зорилгоор ярилцлага хийх, дугуй ширээний ярилцлага хийх, хэвлэлийн бага хурал хийх, олон нийтэд хандсан янз бүрийн үйл ажиллагаанд хэвлэл мэдээллийн хэрэгслийг урих үзэгдэл орох боловч үүгээр хязгаарлагдахгүй. Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй хийсэн эдгээр ажил хэрэг нь удахгүй болох

сонгуулийн арга хэмжээ, чухал эцсийн хугацаа, сонгогчийн бүртгэлийн боломж, санал өгөх сонголт болон бусад олон зүйлийн талаар найдвартай мэдээллээр олон нийтийг хангана.

Түүнчлэн RR/CC нь олон нийтэд түшиглэсэн байгууллагууд, Тойргийн оролцогч талууд, өмгөөллийн хороод, хотын захиргаа, ахлах сургууль, коллеж, их дээд сургууль зэрэг удаан хугацааны түншүүдтэй үргэлжлүүлэн хамтран ажиллах боловч үүгээр хязгаарлагдахгүй. Энэ түншлэлүүдээр дамжуулан RR/CC нь манай асар том олон соёлт нийгмийн бүлгүүдэд эрт санал өгөх боломжоо хэрхэн ашиглах, иргэдийн оролцоо, сонгогчийн оролцоог сурталчлах талаар мэдлэгийг дээшлүүлэх, боловсрол олгох зорилгоор олон хэл дээр хүрч үйлчлэх материалаар хангаж, хамтран ажиллана.

1-A ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ БОЛОН ХҮРЧ ҮЙЛЧЛЭХ ТӨСӨВ

RR/CC-н хэвлэл мэдээллийн болон хүрч үйлчлэх төсөв нь 21-22 оны санхүүгийн жилд 6,300,000 доллар байна. Тойргийн санхүүгийн жил долдугаар сараас зургадугаар сар хүртэл үргэлжилнэ. Иймд 2022 оны зургадугаар сарын 7-ны Муж улсын анхан шатны шууд сонгууль болон 2020 оны арван нэгдүгээр сарын 3-ны Ерөнхий сонгуулийн боловсрол, сурталчилгаатай холбоотой урьдчилсан зарим зардлыг энэ төсөвт багтаасан болно. Тойргийн сонгогчид болон оршин суугчдад хууль ёсны санал өгөх эрх, санал өгөх сонголт, сонгуулийн арга боломжийн талаар боловсрол олгох зорилгоор өргөн цар хүрээтэй, олон хэлээр, олон соёлт сонгогчийн боловсролын кампанит ажлыг хэрэгжүүлэхэд энэ төсвийг зарцуулна.

Хүснэгт 1: Санхүүгийн жилүүдийн зарцуулалтын харьцуулалтууд						
Санхүүгийн жил	ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ			ХҮРЧ ҮЙЛЧЛЭХ		
	Төсөв	Зардал	Зөрүү	Төсөв	Зардал	Зөрүү
СЖ 17-18	\$ 850,000	\$488,656	\$361,344	\$25,000	\$29,773	\$(4,773)
СЖ 18-19	\$1,500,000	\$587,216	\$912,784	\$25,000	\$62,216	\$(37,216)
СЖ 19-20	\$7,467,000	\$360,269	\$7,106,731	\$25,000	\$1,001	\$23,999
СЖ 20-21	\$725,000	\$290,338	\$434,662	\$16,376,000	\$12,804,721	\$3,571,279
СЖ 21-22	\$1,700,000	\$970,101	\$729,899	\$4,600,000	-	\$4,600,000
СЖ 22-23	\$700,000	-	\$700,000	\$2,000,000	-	\$2,000,000

1-В ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХҮРТЭЭМЖ

RR/CC нь Тойргийн олон янзын хүн амд үр дүнтэй хүрч, харилцах хамгийн сайн аргыг тодорхойлохдоо өмнөх сонгогчийн боловсролын кампанит ажлын тайлан, олон нийтийн саналын санал асуулга, үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн мэдээллийн эх сурвалж зэрэг янз бүрийн мэдээллийн эх сурвалжийг ашигладаг. RR/CC нь олон нийтэд тэдгээрийн санал өгөх сонголт, эрхийн талаар хэрхэн боловсрол олгох талаар хамгийн сайн тодорхойлохын тулд өгөгдөлд суурилсан аргыг үргэлжлүүлэн ашиглахын зэрэгцээ онлайнаар болон манай үнэгүй утсаар дамжуулан авах боломжтой найдвартай эх сурвалжид тэднийг чиглүүлнэ.

Хэвлэл мэдээллийн кампанит ажилд олон хэл ба соёлыг хамруулна. Тойргийн янз янзын нийгмийн бүлэгт мэдээллийг хүргэхийн тулд RR/CC нь үндэсний томоохон платформууд болон орон нутгийн жижиг радио станцуудтай хамтран ажиллана. Энэ цогц арга нь сонгогчдод мэдээ, мэдээллээ авдаг аливаа аргаар нь дамжуулан RR/CC-ийн мэдээллийг хүлээн авах боломж олгоно.

Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл

RR/CC нь телевиз, радиогийн англи болон англи бус олон төрлийн өргөн нэвтрүүлгийн сүлжээ, станцуудтай хамтран ажиллаж, олон нийтэд мэдээлэх, мэдээллийн ярилцлага хийх, төлбөртэй оролцоог хэрэгжүүлэх болно. Төрийн үйлчилгээний зарлал, бусад RR/CC хүрч ажиллах хүчин чармайлтын хамт удахгүй болох сонгууль, бүртгэлийн мэдээлэл, хэлний хандалт, санал өгөх сонголтуудын талаархи чухал мэдээллүүдийг агуулсан болно. Эдгээр хүчин чармайлт нь англи болон англи хэлгүй иргэдэд шууд үйлчлэх болно. Өмнөх түншүүдэд дараах орох боловч үүгээр хязгаарлагдахгүй:

- ABC
- iHeart Media
- KPCC
- CBS
- POWER 106
- NPR
- KTLA
- Entercom
- K-ABC
- FOX
- Entravision
- KFI
- NBC
- Liberman Broadcasting
- KJLH
- Telemundo
- KNX
- Univision

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл

RR/CC нь иргэдийн оролцоог сурталчлах, уншигчдад хэрхэн санал өгөхөөр бүртгүүлэх, санал өгөх эрх болон сонголтоо хянах, сонгуулийн нөөцийг олж тогтоох, эрт санал өгөхийг дэмжих чиглэлээр орон нутгийн болон бүс нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй хамтран ажиллана. Үүнд сонин, сэтгүүл, мэдээллийн самбар орно. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь англиас өөр хэлээр ярьж, уншдаг оршин суугчид мөн газарзүйн хувьд тусгаарлагдсан, үйлчилгээ муу авдаг нийгмийн бүлэгт хүрэх найдвартай хэрэгсэл хэвээр байна. Өмнөх түншүүдэд дараах орох боловч үүгээр хязгаарлагдахгүй:

- Los Angeles Times
- LA Daily News
- Daily Breeze
- Pasadena Star News
- Long Beach Press-Telegram
- Whittier Daily News
- San Gabriel Valley Tribune
- LA Sentinel
- La Opinion
- World Journal
- The Korea Times

Дижитал хэвлэл

RR/CC нь сонгогчдын мэдээ, энтертайнментаа авч байгаа газарт хүрэх зорилгоор олон хэлээр үйлчилгээ үзүүлдэг платформ, вебсайт, дамжуулах үйлчилгээгээр статик болон видео сурталчилгаа үзүүлж дижитал платформуудыг үргэлжлүүлэн ашиглах болно. Оршин суугчид мэдээлэл авахдаа, онлайн эх сурвалж болон мэдээлэлд хандахын тулд гар утас эсвэл дижитал төхөөрөмждөө ихээхэн тулгуурладаг тул дижитал хэвлэл нь үр дүнтэй хэвлэл мэдээллийн хэрэгсэл буюу хүрч үйлчлэх гол хэрэгсэл болдог.

Сошиал медиа

RR/CC нь Тойргийн оршин суугчидтай хэрхэн санал өгөхөөр бүртгүүлэх, сонгогчдын оролцоог дэмжих талаар ажиллахдаа сошиал медиа платформыг үргэлжлүүлэн ашиглах болно. Сошиал медиа нь чухал санал хураалт, сонгуулийн мэдээллийг анхаарлын төвд байлгахын тулд тодорхой үзэгчдэд мэдээлэл өгөх, мэдээллийг их хэмжээгээр түгээхэд хамгийн сайн бөгөөд хэмнэлттэй

аргуудын нэг хэвээр байна. Түүнчлэн сошиал медиа нь янз бүрийн платформ дээр тэгш эрхтэй бүлэгтэйгээ харилцах онцгой боломжийг олгодог бөгөөд RR/CC-д асуулт, санал хүсэлтийг шийдвэрлэх эсвэл худал, ташаа мэдээллийг арилгахын тулд сонгогчидтой харилцах боломжийг олгодог.

Та дараах хаягаар RR/CC-г дагах эсвэл мэдээлэлд бүртгүүлэх боломжтой:

- Facebook: facebook.com/LACountyRRCC
- Instagram: @lacountyrrcc
- YouTube: lacountyrrcc
- Twitter: @LACountyRRCC

Э-мэйл маркетинг

RR/CC нь сонгогчийн бүртгэлийн мэдээллийн сантай холбоотой э-мэйл хаягийн өргөн жагсаалтыг ашиглан сонгогчдод эцсийн хугацаа, санал өгөх боломж, санал өгөх боломжоо илүү хялбар, илүү тав тухтай болгохын тулд хүртээмжтэй онлайн хэрэгслүүдэд хэрхэн хандаж болох талаар цаг тухайд нь, найдвартай мэдээлэл илгээнэ.

Гадна зар сурталчилгаа

RR/CC нь оршин суугчдад мэдээлэл илгээхдээ Гадна зар сурталчилгааны янз бүрийн арга боломжийг үргэлжлүүлэн үнэлж, тодорхойлно. Автобусны зогсоол ба хурдны зам дээрх самбар зэрэг дамжин өнгөрөх сурталчилгааны самбарыг өнгөрсөн хугацаанд ашигладаг байсан бөгөөд Тойргийн олон янзын хүн ам, газарзүйн хувьд тусгаарлагдсан нийгмийн бүлгүүдэд сонгуулийн талаарх гол мэдээллийг хүргэхийн тулд энэ аргыг үргэлжлүүлэн судалсаар байна.

Райдшейр/Тээврийн компаниуд

RR/CC нь Санал өгөх төвүүдэд тээврийн үйлчилгээ үзүүлэх зорилготойгоор сонгогчийн бүртгэл, мэдээллийг сурталчлахаар райдшейр компаниуд, Нийслэлийн тээврийн газар, Тойргийн олон нийтийг хамарсан ажлын хэлтэс болон бусад тээврийн байгууллагуудтай үргэлжлүүлэн хамтран ажиллана.

Инфлюенсер ба итгэмжлэгдсэн элч нар

RR/CC нь RR/CC болон түүний түншүүдийн боловсруулсан гол санааг ойлгуулж, дэлгэрүүлэхийн тулд нийгэмлэгийнхээ инфлюенсер болон итгэмжлэгдсэн элч нартай үргэлжлүүлэн ажиллана.

Шууд шуудан

Тойргийн сонгуулийн үеэр RR/CC нь бүртгэлтэй сонгогчид руу шууд хоёр шуудан илгээнэ. Сонгогчдод шууд туслахын тулд RR/CC нь шуудангаар санал өгөх багц дахь саналын хуудас хийх хайрцагны хамгийн ойрын хаягийг өгөх болно. Бүртгүүлсэн сонгогч бүрт оршин суугаа газартаа хамгийн ойр байрлах Санал Өгөх Төвийг харуулсан тусдаа Санал Өгөх Төвийн талаарх шуудан илгээнэ. RR/CC нь ирэх сонгуулийн талаар сонгогчдод мэдлэг олгох, сонгуулийн биечлэн болон шуудангаар санал өгөх цагийн хуваарийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөхийн тулд "Саналын хуудас, шуудангаар санал өгөх" багцаас гадна шууд шуудангийн илгээмжийг үргэлжлүүлэн ашиглах болно. Санал өгөх боломжтой сонголтууд, биечлэн санал өгөх төвүүдийн байршил, сонгогчид RR/CC-ийн үнэ төлбөргүй шуудан, утас эсвэл вэбсайтаар дамжуулан найдвартай, сонгуулийн найдвартай мэдээллийг олж авах боломжтой.

Сонгуулийн мөчлөгт үндэслэн энэ шуудангийн үйлчилгээнд сонгогчид сонгуулийн материалаа англиас өөр хэлээр авахыг хүсэх эсвэл оршин суугаа хаягийн мэдээллээ шинэчлэх боломжтой шуудангийн зардал төлөгдсөн буцаах маягыг оруулж, өгч болно.

1-С ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦОО

Олон нийтэд үр дүнтэй хүрч, VSAP-н талаар мэдээллээр хангахын тулд RR/CC нь Тойрог дахь түнш агентлагууд, засгийн газрын бусад агентлагууд, Хотын ажилтан болон СВО-уудтай үргэлжлүүлэн хамтран ажиллана. RR/CC нь танилцуулга, ажилтнуудын арга хэмжээ зохион байгуулж, сургалт, материалаар хангаж, олон нийтэд тууштай мэдээлэл, санаа хүргэнэ. Эдгээр үйл ажиллагааг дэмжих зорилгоор RR/CC нь нийгмийн бүлэгт VSAP болон VCA-н талаар мэдлэг олгох, мэдээлэл өгөх олон тооны мэдээллийн хуудас, зурагт хуудас бүтээсэн. Эдгээр байгууллагад өгсөн бүх материал VSAP тамгатай бөгөөд тухайн мэдээлэл ач холбогдолтой, үнэн зөв, найдвартай эх сурвалжаас ирсэн гэдгийг олон нийтэд баталгаажуулдаг.

Тойргийн хамтын ажиллагаа/Оролцогч талууд

Олон нийтэд хүрч, тэдэнд боловсрол олгоход олон нийтээс сонгосон албан тушаалтнууд (сонгогдсон болон сонгогдоогүй), засгийн газрын агентлагууд, Тойргийн хэлтэсүүд, хотууд, худалдаа аж үйлдвэрийн танхимууд болон нийгмийн бүлгүүдийн бусад оролцогч талын хамтын ажиллагаа шаардлагатай. Эдгээр байгууллага санал өгөх сонголт, сонгуулийн гол мэдээллийн талаар боловсрол олгож, таниулах чиглэлээр хамтран ажилладаг.

Бусад Тойргийн хэлтсүүдтэй хамтран ажиллах нь RR/CC-н олон нийтэд хүрч, боловсрол олгох чадварыг сайжруулдаг. Тойргийн дараах байгууллагууд нь өмнө нь RR/CC-д тусалж байсан бөгөөд сонгогчийн боловсрол, хүрч үйлчлэх ажилд туслах байгууллагуудын жишээ болно:

- Үнэлгээчин
- Далайн эрэг, боомт
- Удирдагчдын зөвлөл
- Нийтийн номын сан
- Гүйцэтгэх товчоо
- Төрийн нийгмийн үйлчилгээ
- Хэрэглэгч ба бизнесийн асуудал эрхэлсэн хэлтэс
- Олон нийтийг хамарсан ажил
- Тойргийн харилцаа холбоо
- Санхүүгийн ажилтан ба татвар хураагч
- Парк ба амралтын хүрээлэн
- Ажиллах хүчний хөгжил, олон нийтийн үйлчилгээ

Олон нийтийн арга хэмжээ

СВО-н харилцаа холбоо болон төлбөртэй хэвлэл мэдээллийн түншлэлээр дамжуулан Тойргийн хэмжээнд арга хэмжээ хамтран зохион байгуулах, ивээн тэтгэх боломж нь RR/CC-д санал хураалтын шинэ загварын талаар олон нийттэй харилцах үнэ цэнэтэй боломж олгоно. RR/CC нь олон байгууллага болон арга хэмжээ зохицуулагчидтай олон жил хамт ажиллаж байгаа бөгөөд цаашид хурал зохион байгуулж, сонгуультай холбоотой материалыг олон нийтэд хүргэхэд олон амралтын өдрүүдийг зориулна. RR/CC-н энэ жил оролцсон, 2022 онд оролцохоор төлөвлөж байгаа томоохон арга хэмжээг Хүснэгт 2-т онцлов. Эдгээрээс гадна RR/CC нь бусад олон зуун нийгмийн бүлгийн арга хэмжээнд оролцсон.

Хүснэгт 2. Олон нийтийн томоохон арга хэмжээ		
ОГНОО	АРГА ХЭМЖЭЭ	ХОТ
2022 оны хоёрдугаар сарын 13	Bell 5K Resource Fair	Bell
2022 оны гуравдугаар сарын 4	Care Harbor Resource Event	Los Angeles
2022 оны гуравдугаар сарын 5	Care Harbor Resource Event	Los Angeles
2022 оны гуравдугаар сарын 11	Latina History Day	Los Angeles
2022 оны гуравдугаар сарын 15	Townhall Voter Registration	Dominguez Hills
2022 оны гуравдугаар сарын 16	East LA Job and Resource Fair	Los Angeles
2022 оны гуравдугаар сарын 16	Gabrielino HS College and Career Fair	San Gabriel
2022 оны гуравдугаар сарын 24	SOS Event	Domingue Hills
2022 оны тавдугаар сарын 5-31	Pomona FairPlex	Pomona

1-D ВЕБСАЙТЫН МЭДЭЭЛЭЛ

LAVOTE.GOV

RR/CC-н албан ёсны вебсайт болох LAVOTE.GOV нь Тойргийн хэмжээнд санал хураалт, сонгуулийн бүх мэдээллийг олгох үндсэн эх сурвалж, байршил болно. Санал өгөх дадлагыг сайжруулахын тулд вебсайтыг ирэх сонгуулийн талаарх чухал мэдээллүүд, сонгогчийн бүртгэлийн мэдээлэл, санал өгөх сонголт, онлайн эх сурвалжуудаар тасралтгүй шинэчилж байна.

1-E ХЭЛНИЙ ТУСЛАМЖ

Los Angeles тойрог нь улсын хамгийн олон хүн амтай орон нутгийн сонгуулийн харьяалал төдийгүй хамгийн олон хүн амтай тойргийн нэг юм. Соёл, хэл шинжлэлийн олон янз байдал нь хүч чадалтай, идэвхтэй сонгогчдыг бүрдүүлдэг Тойргийн нэг онцлог шинж болно. Хэлний цөөнхийн нийгмийн бүлгүүдэд нээлттэй, хүртээмжтэй ажлыг дэмжихийн тулд RR/CC нь орчуулсан материал, хэлний найдвартай тусламжаар хангадаг. Тойрог нь одоогийн байдлаар сонгогчдод англи хэлнээс гадна дараах хэлээр хэлний тусламж үзүүлж байна:

- Армен хэл
- Хятад хэл
- Камбож/Кхмер
- Фарс
- Солонгос хэл
- Испани хэл
- Тагалог/Филиппин
- Вьетнам хэл
- Хинди
- Япон хэл
- Тай хэл
- Орос хэл
- Бенгаль хэл*
- Бирм хэл*
- Гужарати хэл*
- Индонез хэл*
- Монгол хэл*
- Телугу хэл*

**Эдгээр хэлний үйлчилгээг 2022 оны зургадугаар сарын 7-ны өдрийн Муж улс даяарх шууд анхан шатны сонгуулиас эхлэн нэмнэ. VBM саналын хуудсыг шуудангаар илгээж, Саналын хуудас дээр тэмдэглэгээ хийх төхөөрөмжид эдгээр хэлийг нэмнэ.*

Тойрог нь холбооны болон Муж улсын хэлний шаардлагыг дагаж мөрдөх, бүх сонгогчид шударга, хүртээмжтэй бөгөөд ил тод сонгуулийн үйлчилгээг үзүүлэх зорилгодоо хүрэх цогц арга барилаа цаашид үргэлжлүүлэх үүрэгтэй.

Англи хэлний хязгаарлагдмал мэдлэгтэй (LEP) сонгогчдыг тодорхойлж, үйлчлэх нь

Сонгогч санал өгөхөөр бүртгүүлэх үед өөр хэл дээр орчуулсан сонгуулийн материалыг хүсэж болно. Ийм хүсэлт гаргасан сонгогчид хүссэн хэлээрээ загвар саналын хуудас болон сонгуулийн бүх материалыг орчуулгатай автоматаар хүлээн авна. Мөн RR/CC сонгогчдод зориулсан сонгуулийн орчуулсан материалууд эсвэл Санал өгөх төвийн байршлын талаарх мэдээлэл, хоёр хэлтэй сонгогчдын бүртгэлийн карт, орчуулагдсан VBM аппликэйшнүүд, загвар саналын хуудас авах хүсэлт гаргах Олон хэлээр туслалцаа үзүүлэх тусламжийн утастай.

RR/CC нь АНУ-ын хүн амын тооллого, Америкийн нийгмийн бүлгийн судалгаа, сонгогчийн бүртгэлийн аппликэйшнүүд, нийгмийн бүлгүүдийн хэлний тусламжийн хүсэлт зэрэг олон эх сурвалжаас ирсэн хүн ам зүйн мэдээлэл, хэлний тусламжийн хүсэлтийг нэгтгэсэн зорилтот өгөгдлийн цогц системийг боловсруулсан. Хэлний тусламжийн хэрэгцээнд үндэслэн Санал өгөх төвүүдийн олон хэлтэй ажилтнуудад эрэмбэ тогтоох зорилгоор энэ өгөгдлөөс тайлан гаргадаг. Одоогийн өгөгдөлд үндэслэн Санал өгөх төв болгонд Испани хэлээр ярьдаг Сонгуулийн ажилтнуудыг байрлуулна.

LEP-н нийгмийн бүлгүүдэд Санал өгөх төвүүдийн талаар боловсрол олгох, харилцах нь

2017 онд байгуулагдсан RR/CC-н Хэлний хүртээмжтэй байдлын зөвлөх хороо (LAAC) нь LEP-н нийгмийн бүлгүүдэд ирэх сонгууль болон санал өгөх сонголтын талаар боловсрол олгоход чухал үүрэг гүйцэтгэдэг. LAAC-н гишүүд олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах болон орчуулсан материалыг нийгмийн бүлэгт түгээх зэргээр тусалдаг. LAAC байгууллагуудын зарим хэсэг нь:

- Asian Americans Advancing Justice
- California Common Cause
- Center for Asian Americans United for Self Empowerment (CAUSE)
- Korean American Coalition
- League of Women Voters (LWV), Los Angeles
- NALEO Educational Fund
- National Iranian American Council
- Pars Equality Center

- South Asian Network (SAN)
- United Cerebral Palsy of Los Angeles

RR/CC нь LAAC-тай зарим асуудлаар үргэлжлэн хамтран ажиллах, хэлний үйлчилгээг тэлэх, сайжруулах, LEP нийгмийн бүлгүүдтэй харилцан ажиллах зорилгоор улирал бүр уулзалт хийдэг. Хорооны хуралд хэрхэн оролцох, оролцох болон/эсвэл нэгдэх гэх мэт нэмэлт мэдээллийг LAVOTE.GOV дээрээс авах боломжтой.

1-F ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДЛЫН ДЭМЖЛЭГ

RR/CC нь тусгай хэрэгцээт хүмүүст зориулан сонгуулийн хүртээмжтэй байдлыг бүрэн хангахаар хичээнгүйлэн ажилладаг бөгөөд Санал өгөх төвүүдийг судлах, элсүүлэх, өөрчлөх, хэвээр нь хадгалах талаар дорвитой алхмуудыг үргэлжлүүлэн хийнэ.

Санал Өгөх Төвийн загварыг тусгай хэрэгцээт сонгогчидтой ойрхон байлгахгаар мөн бүх сонгогчдод хүртээмжтэй байлгахгаар Санал Өгөх Төвүүдийг зохион бүтээсэн. Санал өгөх төвүүдийн дүгнэлтээс авч үзэхэд Санал өгөх төвийн үйл ажиллагаа эрхэлж буй байгууламжууд нь бусад шалгуураас гадна хүртээмжтэй зогсоолын шаардлагыг хангасан байх шаардлагатай. RR/CC нь Олон нийтийн сонгогчтой харилцах хороо (CVOC) болон Санал өгөх хүртээмжтэй байдлын зөвлөх хороогоор (VAAC) дамжуулан нийгмийн бүлэгтэй хамтран ажилладаг. Тойргийн VAAC нь 2006 онд RR/CC-д хүртээмжтэй байдал, оролцоог сайжруулах шинэлэг стратегийг хэрэгжүүлэхэд туслах зорилгоор байгуулагдсан. VAAC нь сонгуулийн өмнөх болон сонгуулийн дараах үйл ажиллагаанд RR/CC-д туслахад чухал үүрэг гүйцэтгэсэн.

RR/CC нь VAAC-тай хамтран Сонгуулийн ажилчдад тусгай хэрэгцээт сонгогчидтой хэрхэн харилцах талаар боловсрол олгох зорилгоор Тусгай хэрэгцээт байдлыг таниулах сонгуулийн ажилтны сургалтын видеог бүтээсэн. Энэ видео нь Сонгуулийн ажилтны сургалтын хөтөлбөрт тусгагдсан бөгөөд тусгай хэрэгцээт сонгогчдод үзүүлэх үйлчилгээний талаар сонгогчдодоо мэдээлэл өгөх зорилгоор нийгмийн бүлгүүд ашиглах боломжтой.

Хүртээмжтэй байдлыг сурталчлах байгууллагуудтай хамтран ажиллах нь

2006 онд байгуулагдсан RR/CC-ийн Санал хураалтын хүртээмжтэй байдлын зөвлөх хороо (VAAC) нь сонгогчдод хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор хэрэгжиж буй олон янзын хөтөлбөр, үйл ажиллагаа, үйлчилгээ, хэрэгслийн талаар сонгогчдод мэдээлэл олгоход чухал үүрэг гүйцэтгэдэг. VAAC-ийн гишүүд олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахад тусалж, тусгай хэрэгцээт сонгогчидтой холбогдох, орчуулсан материалыг нийгмийн бүлэгт түгээх тал дээр RR/CC-тэй хамтран ажилладаг. VAAC-д багтдаг зарим байгууллагууд:

- Чадвар нэгдүгээрт
- CA-ийн хараагүйчүүдийн зөвлөл
- CALIF бие даан амьдрах төвүүд
- Тусгай хэрэгцээт иргэний эрх California
- Бүс нутгийн төвүүд
- Нэгдсэн тархины саажилт Los Angeles
- Тусгай хэрэгцээт иргэдийн судалгаа ба олон нийтийн оролцооны USC төв

RR/CC нь VAAC-тай хамтран санал хураалтын явцад үзүүлж болох хүртээмжтэй байдлын талаар олон нийтэд үргэлжлүүлэн мэдээлнэ. RR/CC нь VAAC-тай зарим асуудлаар үргэлжлэн хамтран ажиллах, хүртээмжтэй байдлын үйлчилгээг сайжруулах, тусгай хэрэгцээт сонгогчидтой харилцан ажиллах зорилгоор улирал бүр уулзалт хийдэг. Хорооны хуралд хэрхэн оролцох, оролцох болон/эсвэл нэгдэх гэх мэт нэмэлт мэдээллийг LAVOTE.GOV дээрээс авах боломжтой

Хүртээмжтэй үйлчилгээнүүд – ISB, RAVBM, VBM, BMD

Тойргийн ISB, RAVBM, VBM, BMD нь тусгай хэрэгцээт сонгогчдын нэмэлт хүртээмж, тав тухыг хангах хэрэгсэл болно. Эдгээр хэрэгсэл бүгдийг нь VSAP шийдлийн үндсэн бүрэлдэхүүн хэсэг болгон зохион боловсруулж, хэрэгжүүлсэн. Сонгогчид, сонгуулийн ажилчдын олон нийтийн байгууллагууд, орон нутгийн сонгуулийн албан хаагчид болон технологи, хүртээмж, аюулгүй байдлын мэргэжилтнүүдийг оролцуулсан, хүн төвтэй, хамтын ажиллагааны шийдэлтэй үйл явцыг ашиглан эдгээр хэрэгслийг боловсруулж, хэрэгжүүлсэн. Тухайн үйл явцын нэг хэсэг болгож ашиглахад хялбар байдал болон хүртээмжтэй байдлыг хангах үүднээс хэрэгслүүдийг хэрэглэгчдэд

зориулсан дэлгэрэнгүй туршилтад оруулсан. 14 үндсэн зарчмыг харгалзан үзээд эдгээр хэрэгслийг боловсруулсан. Эдгээр зарчимд:

1. Ил тод байдал
2. Санал өгөх сонголтуудаар хангах боломж
3. Нууцлал
4. Ашиглахад хялбар байдал болон хүртээмжтэй байдал
5. Итгэлтэй байдал
6. Шударга байдал
7. Хамгаалалт
8. Үр ашигтай ажиллагаа
9. Чадлын цараа
10. Уян хатан байдал
11. Тохируулахад хялбар байдал
12. Минимал хүч
13. Минимал төлөвлөлт
14. Авсаархан байдал

RR/CC-ийн вебсайтад байрлах веб-д суурилсан аппликэйшнээр дамжуулан ISB-д хандаж болно. ISB нь 19 хэл дээр байдаг бөгөөд туслах технологийг ашиглан хандаж болох ба ашиглахад, ойлгоход хялбар байхаар бүтээгдсэн. ISB нь хэрэглэгчдэд загвар саналын хуудсаа тэмдэглэх мөн хэвлэх эсвэл гар утсан дээрээ татаж авах боломжтой Санал өгөх тасалбар үүсгэх боломж олгоно. Санал өгөх тасалбар нь сонгогчдод загвар саналын хуудсаа BMD руу хурдан шилжүүлэх, сонголтоо баталгаажуулах, өөрчлөх, санал өгөх үйл явцыг дуусгах боломжийг олгож Саналын төвд санал өгөх явцыг хурдасгадаг.

Сонгогчдод санал өгөх явцыг өөрсдийн чадварт тохируулан өөрчлөх боломжийг олгодог олон функцийг бүх BMD санал болгодог. BMD бүр тэргэнцэр эсвэл таягтай сонгогч үйлчилгээ авах боломжтой хангалттай зайтай. Мэдрэгчтэй дэлгэцийг сууж байгаа болон зогсож байгаа сонгогчдод зориулан тохируулж болно. Мэдрэгчтэй дэлгэц ашиглах боломжгүй эсвэл ашиглахад бэрхшээлтэй тулгардаг хүмүүст зориулсан BMD нь саналын хуудсыг удирдах, сонголт хийх товчлуур бүхий мэдрэгчтэй гартай. Харахад хялбар болгох үүднээс BMD дэлгэцийн үсгийн хэмжээ, өнгө, тодосгогчийг сонгогч тохируулах боломжтой. BMD бүр сонгогчдод саналын хуудасны асуулт, сонголтыг сонсох боломжийг олгодог суурилуулсан аудио чихэвчтэй. Аудио хурд болон дууны

түвшнийг сонгогч өөрөө тохируулах боломжтой. Мөн 2022 оны байдлаар BMD нь аудио болон мэдрэгчтэй дэлгэцийн интерфэйсийг 20 хэлээр танилцуулж байгаа.

Тойргийн VBM саналын хуудас болон дугтуйг хэрэглэхэд амар байхаар зохион бүтээсэн ч RR/CC нь мөн RAVBM-г санал болгодог. Энэ хэрэгслийн тусламжтайгаар сонгогч RR/CC-н вебсайтад байрлах веб-д суурилсан аппликэйшн рүү хандаж саналын хуудсыг дэлгэцэн дээр үнших боломжтой хэлбэрээр үзэх боломжтой. Сонгогчид сонголтоо үншиж эсвэл тэмдэглэхдээ туслах технологи/төхөөрөмжийг ашиглах боломжтой. Сонгогч дараа нь саналын хуудсаа хэвлээд RR/CC руу шуудангаар илгээх эсвэл Санал өгөх төвд өгөх эсвэл Саналын хуудасны хайрцагт хийх ёстой.

Биечлэн санал өгөх болон VBM сонголт нь бүх сонгогчид бие даасан, хувийн, аюулгүй санал өгөх боломжийг олгодог.

2-Р ХЭСЭГ – САНАЛ ӨГӨХ ТӨВ, САНАЛЫН ХУУДАСНЫ ХАЙРЦГИЙН БАЙРШИЛ

VCA нь Тойргийн хэмжээнд тав тухтай, аюулгүй, хүртээмжтэй Санал Өгөх Төвүүд болон санал өгөх хайрцаг байлгахыг Тойргоос шаарддаг. Энэ шаардлагаар эдгээр газрын байршил, ажиллах өдрийн тоо, ажиллах цагийг сонгох хамгийн бага шалгуурыг тогтоодог. Тойрог нь Los Angeles тойргийн сонгогчдод зориулж хамгийн сайн байршлыг тогтоож өгөхийн тулд өргөн хүрээнд судалгаа, дүн шинжилгээ хийж, байршлын мэдээллийг сонгогчдод өгөхийн тулд өргөн хүрээний кампанит ажлыг эхлүүлнэ. Санал Өгөх Төв болон санал өгөх хайрцгийн байршлын мэдээллийг сонгууль бүрийн өмнө LAVOTE.GOV сайт дээр байршуулна. Мөн янз бүрийн захидал түгээгчээр дамжуулан байршлын мэдээллийг сонгогчидтой хуваалцана.

2-А САНАЛ ӨГӨХ ТӨВ

Санал өгөх төвийн байршил

Санал өгөх төвийн хамгийн тохиромжтой байршлыг тодорхойлоход хүний зан төлөв, хэв маягийг урьдчилан таамаглахын зэрэгцээ Муж улс, орон нутгийн шаардлагыг орон зайн болон нийгэм, эдийн засгийн нөхцөлтэй уялдуулсан найдвартай, өгөгдөлд суурилсан үйл явц шаардагдана. RR/CC нь хамгийн бага VCA шалгуураас давсан нийгмийн бүлгүүддээ зориулан Санал өгөх төвийн хамгийн тохиромжтой байршлыг тодорхойлох цогц стратегийг ашигладаг.

RR/CC нь хамгийн тохиромжтой Санал өгөх төвийн байршлыг тодорхойлохдоо дараах 14 шалгуурыг тусгасан:

1. Газарзүйн хувьд тусгаарлагдсан нийгмийн бүлгүүд

2. Бага орлоготой нийгмийн бүлгүүд
3. Англи хэлээр хязгаарлагдмал ярьдаг болон хэлний цөөнхийн нийгмийн бүлгүүд
4. Тээврийн хэрэгсэл бага эзэмшдэг нийгмийн бүлгүүд
5. Сонгогчийн оршин суугаа хүн амын төвүүд
6. Хөдөлмөр эрхлэлтийн төвүүдтэй ойрхон байдал
7. Тусгай хэрэгцээт сонгогчид
8. Бүртгэлгүй сонгууль өгөх эрхтэй сонгогчид
9. VBM хэрэглээ бага
10. Санал өгөх өндөр магадлалтай бүртгэлтэй сонгогчид
11. Шинээр санал өгөх сонгогчид
12. Транзит нэвтрэх
13. Замын түгжрэл ба төлөв
14. Нийтийн хүртээмжтэй зогсоол

Los Angeles тойргийн байгууламжийн үнэлгээ

VCA нь 2022 оны зургадугаар сарын 7-нд болох Муж даяарх шууд анхан шатны сонгуулийн санал авах өдрөөс 10 хоногийн өмнө ойролцоогоор 114 санал өгөх төвийг ажиллуулахыг шаарддаг боловч RR/CC-н зорилго нь 120 байна. Мөн сонгуулийн өдрөөс 3 хоногийн өмнө, мөн сонгуулийн өдрийг оролцуулан VCA нь Тойрогт хамгийн багадаа 568 санал өгөх төвийг ажиллуулахыг шаарддаг ч RR/CC-н зорилго нь 640 байна.

Санал өгөх төвүүдийг эцэслэн батлах, баталгаажуулахын тулд RR/CC нь хүртээмжтэй байдал, зохих эрчим хүч, сүлжээний холболтыг баталгаажуулах боломжит сайт тус бүр дээр иж бүрэн судалгаа хийдэг. Судалгааг дуусгасны дараа RR/CC нь Санал өгөх төв бүрийн тодорхой огноо, цаг, өрөөний хуваарилалтыг тодорхойлсон Байгууламж ашиглах гэрээнд гарын үсэг зурж дуусгахаар ажиллана.

Санал өгөх төвүүдийн ажиллах цаг

Санал өгөх төвүүд санал өгөх өдрөөс 10 хоногийн өмнө ажиллаж эхэлснээр амралтын хоёр өдөрт сонгогчид санал өгөх төвийн аль ч байршилд санал өгөх боломжтой болно. Санал авах төвүүд санал хураах эхний 10 хоногт өдөрт 9-өөс доошгүй цаг, сонгуулийн өдөр өглөөний 07.00-20.00 цагийн хооронд ажиллана.

2-В САНАЛЫН ХАЙРЦАГ

Саналын хуудасны хайрцгийн байршил нь сонгогчдод, ялангуяа хөдөө орон нутагт амьдардаг, байнга аялдаг, Тойргийн хилээс гадуур ажилладаг хүмүүст хүртээмжийг нэмэгдүүлэхэд чухал үүрэгтэй. VCA-н дагуу саналын хуудасны хайрцаг нь аюулгүй, хүртээмжтэй, нийтийн тээврийн тогтоосон маршрутад аль болох ойрхон байх ёстой. Саналын хуудасны хайрцаг нь сонгуулийн санал авах өдрийг оруулаад 29-өөс доошгүй хоногийн өмнө ердийн ажлын цагаар нээлттэй байх ёстой. Мөн энгийн ажлын цагийг оруулаад өдөрт дор хаяж 12 цагийн түрш хүртээмжтэй, найдвартай, ашиглах боломжтой дор хаяж нэг саналын хуудасны хайрцаг байх ёстой.

Саналын хуудасны хайрцгийн байршлын талаарх зөвлөмжийг VCA шалгуур болон газарзүйн тархалтыг үндэслэн тодорхойлно. VCA-н дагуу Тойрогт 2022 оны зургадугаар сарын 7-нд болох Муж улс даяарх шууд анхан шатны сонгуулийн саналын хуудасны хайрцаг нь дор хаяж 379 байх шаардлагатай. RR/CC одоогоор Тойргийн хэмжээнд 24 цагийн түрш ажилладаг 380 саналын хуудасны хайрцаг суурилуулсан байна. 2022 оны зургадугаар сарын 7-нд болох Муж даяарх анхан шатны шууд сонгуулийн өмнө орон даяар болсон өмнөх сонгуулиудтай нийцүүлэн нийт 400 саналын хайрцагт 20 саналын хуудас буулгах хайрцгийг нэмж суурилуулна. Нэмэгдсэн саналын хуудасны хайрцгийн байршил 2-В хэсэгт дурдсан Санал өгөх төвийн үйл явцтай адил нэмэлт үнэлгээ хийгдэж байна. Мөн санал өгөх бүх төвүүд саналын хуудас өгөх газар болж үйлчилнэ.

3-Р ХЭСЭГ – САНАЛ ӨГӨХ ТӨВИЙН БҮТЭЦ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, АЖИЛЧИД

3-А АЖИЛЧДЫН ЛОГИСТИК, ОЛОН ХЭЛНИЙ ҮЙЛЧИЛГЭЭ

Los Angeles тойргийн Санал өгөх төвийн загвар нь Тойрог даяар янз бүрийн түвшний оролцоог хангахад зориулагдсан. Тойрог нь жижиг, дунд, том гэсэн гурван хэмжээтэй санал өгөх төвүүдийг байрлуулна (Хүснэгт 3-ыг үзнэ үү). Санал өгөх төв тус бүр нь хэмжээ болон санал өгөх хугацаанд ажиллах өдрийн тооноос хамааран 5-27 сонгуулийн ажилтантай байна. Санал өгөх төвийн хэлний шаардлагыг биелүүлэхийн тулд найм (8) хүртэлх хоёр хэлээр ярьдаг хүмүүсийг томилж болно.

Хүснэгт 3. Санал өгөх төвийн босго хэмжээ		
Санал өгөх төвийн хэмжээ	Шаардлагатай хавтгай дөрвөлжин фут	BMD-г дэмждэг
Жижиг	1,775 – 3,274	15 - 20
Дунд	3,275 – 4,499	25-30
Том	>4,500	35-45

Дараах нь RR/CC-н тодорхойлсон Сонгуулийн ажилтны санал өгөх төвд хариуцах үүрэг юм:

- **Ахлах** – Санал өгөх төвийг нээх, хаах, асуулт/асуудлыг шийдвэрлэх, саналын хуудсыг Бүртгэлийн төвүүдэд (CIC) хүргэх зэрэг бүх үйл ажиллагааг хянадаг.
- **Ахлагчийн туслах** – Ахлагчийн бүх үүргийг гүйцэтгэхэд туслах ба ахлагч байхгүй үед ахлах үүргийг гүйцэтгэдэг.
- **Эгнээ хянагч** - Сонгогчидтой мэндчилж, ерөнхий асуултуудад хариулж, зохих станц руу чиглүүлнэ (жишээ нь: Бүртгэлийн ажилтан, VBM ажилтан гэх мэт). Сонгогчдод ISB-н үйл явцад тусалж, чиглүүлж, BMD-г хэрхэн ашиглах талаар зааварчилгаа өгч эгнээг зохих ёсоор байлгахыг баталгаажуулдаг. Ойролцоох санал өгөх төвүүдийн жагсаалтыг сонгогчид урт дараалал үүсэх эсвэл хүлээх цагтай тохиолдолд бэлэн байдлаар өгнө.
- **Зогсоох станцын ажилтан** - Сонгогчдод COVID-19 удирдамжийн талаар зааварчилгаа өгч, санал өгөх төв рүү орохын өмнө бүх удирдамжийг хангасан эсэхийг баталгаажуулна.
- **Бүртгэлийн ажилтан** – Сонгогчдыг шалгаж, саналын хуудсаар хангаж, санал өгөх талбай руу чиглүүлнэ.
- **Санал өгөх талбайн хянагч** – Сонгогчдыг боломжтой BMD руу чиглүүлж, BMD-н үндсэн асуулт/асуудлыг олж засварлаж, шаардлагатай бол Эгнээ хянагчид тусална.
- **Талбайн туслах техникч** – Санал өгөх төвийн тоног төхөөрөмжийн асуудлыг шийдвэрлэнэ (жишээ нь, BMDs, ePollBooks, Routers гэх мэт). Бүх сонгуулийн тоног төхөөрөмж, хүлээлгийн хугацаа, саналын хуудасны тооллого, RR/CC-н системд тохиолдсон тохиолдлын бүртгэлийг хадгалахад тусалдаг.
- **Түр зуурын/VBM ажилтан** – Түр зуурын болон CVR сонгогчдод тусалж, сонгогчдоос VBM дугтуй хүлээн авч, “Би санал өгсөн” наалт өгнө.

3-В САНАЛ ӨГӨХ ТӨВИЙН ТУСЛАМЖ


Тойргийн Санал өгөх төв бүр BMD-тэй байх бөгөөд эдгээр нь бүх сонгогч саналын хуудсаа бие дааж буюу хувийн байдлаар тэмдэглэх боломж олгодог бүрэн нэвтрэх боломжтой санал өгөх төхөөрөмж юм. Түүнчлэн сонгуулийн бүх ажилчид санал өгөх үйл явцын үе шат бүрд тусгай хэрэгцээт сонгогчдод туслах сургалтад хамрагдана. Үүнд тусгай хэрэгцээт сонгогчдод маш их тус болох BMD дээр байх боломжит аргын талаар чиглэсэн сургалт орно. Бүх санал өгөх төвүүдэд ашиглах боломжтой нэмэлт төхөөрөмжид томруулдаг шил, гарын үсгийн заавар, том бариултай үзэг, 20/20 үзэг, замын хажуу дахь санал хураалтын үйлчилгээ зэрэг багтана.

Санал Өгөх Төвүүд нь мөн замын хажуу дахь санал хураалтын үйлчилгээ үзүүлдэг. Санал өгөх төв рүү орох боломжгүй эсвэл ороход хүндрэлтэй байдаг сонгогчдод энэ үйлчилгээг зориулсан болно. Замын хажуу дахь санал хураалт явуулснаар сонгогчид санал өгөх төвийн гадаах зориулалтын хэсэгт тодорхой бичсэн утасны дугаар руу залгаж машинаасаа санал өгөх, Сонгуулийн ажилтнаар санал өгөх материалыг машиндаа аваачиж, бие даан, хувийн байдлаар санал өгөх боломж сонгогчдод олгоно. Сонгогчид ISB эсвэл цаасан саналын хуудсыг ашиглан саналаа тэмдэглэх сонголттой.

3-С САНАЛ ӨГӨХ ТӨВИЙН БҮТЭЦ

Хэсэг 3-А-д дурдсанчлан Санал өгөх төв янз бүрийн хэмжээтэй байх болно. Гэхдээ ерөөний зохион байгуулалт, Санал өгөх төв тус бүрийн онцлог шинж чанараас хамааран санал өгөх төв бүрийн BMD-н нарийвчилсан тоо өөр байж болно. Сонгогчдод хувийн болон бие даан санал өгөх боломжтой байдлаар BMD-г байрлуулахын тулд Санал өгөх төв бүрийг диаграмаар хангана. Бүтэц нь сонгогчдод хүртээмжтэй байх шаардлагад нийцсэн байх ёстой бөгөөд байршил бүрийн хэлбэр, ерөөний хэмжээ өөр байхаар тохируулна. Санал өгөх төвийн жижиг хэмжээний жишээг харуулсан диаграммыг доор харуулав.

Санал өгөх төвийн бүтцийн жишээ



4-Р ХЭСЭГ – АЮУЛГҮЙ БАЙДАЛ, САНАМСАРГҮЙ ТОХИОЛДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

4-A АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АРГА БА СТАНДАРТ

Тойргийн санал өгөх төвүүдэд явуулсан бүх санал хураалт нь Муж улсаас тогтоосон аюулгүй байдлын стандартууд, RR/CC-н аюулгүй байдлын журам, Калифорнийн сонгуулийн хууль, Калифорнийн сонгуулийн системийг ашиглах журмыг дагаж мөрдөнө. Үүнд Санал өгөх төвийн бүх тоног төхөөрөмжийг эдгээр журмын дагуу битүүмжлэх, хүргэх, хадгалах, ашиглах, бүх төхөөрөмж, саналын хуудастай харьцах үйл явцыг баримтжуулсан байх зэрэг орно. Мөн сайт нээлттэй байх үед дор хаяж Сонгуулийн хоёр ажилтан байх ёстой.

4-B САНАЛ ӨГӨХ ТӨВИЙН ДЭМЖЛЭГ

Санал өгөх төвүүдэд ажиллаж байгаа ажилтнууд болон техникийн болон нийцлийн дэмжлэг үзүүлж буй бүх ажилтнууд онцгой байдлын тохиолдолд санал хураах төхөөрөмжийг ажиллуулах, санал өгөх төвийг тохируулах, сонгогчдод туслах, мэдрэмтгий төхөөрөмжийг хамгаалах, зөв горимын талаар өргөн хүрээний сургалтад хамрагдана.

Санал өгөх төвийн бүх ахлагч болон талбайд тусламж үзүүлэх техникийн ажилтнуудад (FST) шаардлагатай үед сонгуулийн ажилтнуудтай холбогдох ухаалаг утас олгоно. Утаснууд нь онцгой

нөхцөлд зориулагдсан бат бөх, найдвартай, эвдэрдэггүй төхөөрөмжүүд болно. Эдгээр төхөөрөмж нь Ахлагч болон FST-үүдийг хурдан харилцах боломж олгож, RR/CC-д бүх санал өгөх төвүүдэд нэгэн зэрэг шинэчлэлт, зурвас илгээх боломжийг олгоно. RR/CC нь төхөөрөмжийг алсаас унтрааж, утасны тохиргоог өөрчилж, утсаа хаясан, алдсан тохиолдолд түгжих зэрэг аюулгүй байдлын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

RR/CC нь залгаж буй хүмүүсийн асуудлыг шийдвэрлэхэд нь туслах бэлэн ажилтнуудтай, бэлтгэгдсэн дуудлагын төвтэй байх болно. Сонгуулийн бүх ажилтан болон техник, журмын дагуу дэмжлэг үзүүлж буй хүмүүс онцгой байдлын үед ажиллах арга хэмжээний талаар сургалтад хамрагдаж, онцгой байдлын үед Санал өгөх төвийг ажиллуулах, сонгогчдод туслахад зориулсан сургалтын гарын авлагатай болно.

4-C КИБЕР ХАМГААЛАЛТ

Кибер хамгаалалт, сонгуулийн шударга байдлыг хангах нь RR/CC-н чухал тэргүүлэх явдал юм. RR/CC-н Мэдээллийн технологийн баг нь RR/CC-н төлөвшлийн түвшнийг дээшлүүлэхийн зэрэгцээ салбарын стандарт, шилдэг туршлагад нийцүүлэхийн тулд Засаглал, Эрсдэл, Нийцлийн (GRC) тогтолцоог баталсан. RR/CC нь сүлжээний аюулгүй байдлыг сайжруулсан бөгөөд сэжигтэй эсвэл аюултай тохиолдлуудад идэвхтэй хариу өгөхийн тулд тасралтгүй хяналт тавина. Мөн Сонгогчдын Э-Бүртгэлийн Программыг төвлөрсөн удирдлагаар удирдаж, холболтууд нь амарч байхад, хөдөлж байх үед болон дамжин өнгөрөх үед шифрлэлтийг хэрэгжүүлэхэд туслах зорилгоор шифрлэгдсэн. Эцэст нь, сэжигтэй бөгөөд аюултай тохиолдлуудад идэвхтэй хариу үйлдэл үзүүлэхийн тулд байнгын хяналт тавих зорилгоор сонгуулийн тусгай хамгаалалтын үйл ажиллагааны төвийг (SOC) байгуулсан.

4-D САНАМСАРГҮЙ ТОХИОЛДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

RR/CC нь Санал өгөх төвд гарсан аливаа эрсдлийг арилгах найдвартай төлөвлөгөөтэй байдаг. Хэрэв нэг Санал өгөх төв нөгөөгөөс ихээхэн хол бол RR/CC нь нэн даруй Санал Өгөх Шуурхай Төвийг байршуулна. Энэхүү санал өгөх шуурхай төв нь Сонгогчдын Э-Бүртгэлийн Програм болон BMD-г тохируулахад шаардлагатай ажилтан болон бүх тоног төхөөрөмжөөс бүрдэнэ. Санал өгөх шуурхай төвийг байршуулж, тохируулж байх хооронд Сонгуулийн ажилчид сонгогчдыг ойролцоох Санал өгөх төв рүү чиглүүлнэ.

Шаардлагатай бол RR/CC нь сонгогчдод мэдээлэл өгөхийн тулд хууль сахиулах байгууллага, Төрийн нарийн бичгийн даргын албанд мэдэгдэж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ. Хэрэв

байгалийн гамшиг эсвэл бусад хүчин зүйл Санал өгөх төв эсвэл саналын хуудасны хайрцгийн ашиглалтын байдалд нөлөөлвөл сонгогчдыг өөр газар луу чиглүүлэх нэмэлт мэдэгдэл, тэмдэг, ажилтнуудад бэлэн байна.

Санал өгөх төвийн бүх үйл ажиллагаа санал хураах хугацаанд зогссон тохиолдолд Сонгуулийн ажилтнууд Калифорнийн сонгуулийн тухай хууль болон саналын хуудас үйлдвэрлэх, дүүсгах удирдамжийн дагуу Санал өгөх төвийн санал өгөх төхөөрөмжийг нэн даруй хамгаалж, саналын бүх материалыг бүртгэнэ. RR/CC нь шинээр орлох Саналын төвийг нээж, өөрчлөлтийн талаарх мэдээллийг олон нийтэд өргөнөөр түгээхийг оролдоно.

5-Р ХЭСЭГ – УРАГШЛАХ НЬ

Los Angeles тойргийн сонгогчид улам ихэссээр байна. Тэдний хамаарах нийгмийн бүлгүүд ч мөн өөрчлөгдөж, технологид илүү хамааралтай болж, ая тухыг эрхэмлэдэг болсон. RR/CC нь Тойргийн сонгогчдод хамгийн сайн үйлчилгээ үзүүлэхийн тулд шаардлагатай бол энэ төлөвлөгөөг тохируулж уян хатан, хариу үйлдэл үзүүлнэ.